

“Далай арвижих” хадгаламж, зээлийн хоршооны
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 25.1.8, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, Хорооны 2006 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 3 дугаар хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа зөрчиж ажилласан “Далай арвижих” хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2008 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

2.Тус хоршоог татан буулгах ажлын явцад хяналт тавьж, 4/21 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээг буцаан авч, энэ тогтоолын талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон харьяалах татварын албанд мэдэгдэхийг Хадгаламж, зээлийн хоршоодын газар /Б.Мөнхжаргал/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ